



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

“Буудайн цацал” ХК-ийн хяналтын багц эзэмшигчээс  
Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, хувьцааг худалдан авахаар  
гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 57.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Буудайн цацал” ХК-ийн нийт гаргасан 72,076 ширхэг хувьцааны 80,52 хувь буюу 58,037 ширхэг хувьцааг эзэмшигч болох Л.Ганбатаас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 19,48 хувь буюу 14,039 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 200 /хоёр зуун/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2014 оны 11 дүгээр сарын 24-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Буудайн цацал” ХК-ийн хувьцаа эзэмшигч Л.Ганбатаас бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хувьцаа эзэмшигч Л.Ганбатад үүрэг болгосугай.

1/ Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийг цаашид компанийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000443